



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАЛ

Огноо: 2017 оны 04 дүгээр сарын 28 -ны өдөр

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр “1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил”-ын 6 төсөл, Улаанбаатар хотын геозкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны 1 төсөл, Монгол орны төв болон зүүн бүсийн алтны хүдэржилт, хэтийн төлвийн судалгааны 1 төсөл, Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих голлох ашиг малтмалын хэтийн төлвийн судалгааны 1 төсөл, Налайхын нутаг дэвсгэрт гүйцэтгэх чичирхийллийн судалгааны 1 төсөл, Ашигт малтмалын төрөлжсөн судалгаанд сансрын зураг ашиглан тайлал хийх 1 төслийг тус тус хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь дор дурдсан нэр бүхий геологийн судалгааны ажил байна. Үүнд:

Багцын дугаар	Төслийн нэр, байршил, аймаг, сумын нэр, код, (эхлэх, дуусах хугацаа)	Геологийн даалгавар /шийдэх асуудал/
1	2	3
1. Геологийн зураглал, эрлийн ажил		
1	Номгоны нуруу-50 Өмнөговь аймгийн Хүрмэн, Номгон сумдын нутагт Хавтгай: К-48-29-А,Б,В,Г К-48-30-А,Б,В,Г Код: НоН-50 (2017-2020 он)	3028.87 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлвийн үнэлгээ өгөх.
2	Тээгийн гол-50 Булган аймгийн Хишиг-Өндөр, Орхон, Могод, Бүрэгхангай сумдын нутагт Хавтгай: М-48-123-А,Б,В,Г М-48-135-А,Б,В,Г Код: Тэг-50 (2017-2019 он)	2738.0 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлвийн үнэлгээ өгөх.
3	Олон гол-50 Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Шинэ-Идэр, Галт, Рашаант, Архангай аймгийн Цэцэрлэг сумдын нутагт Хавтгай: М-47-105-А,Б,В,Г М-47-106-А,Б,В,Г Код: ОГ-50 (2017-2020 он)	2697.0 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлвийн үнэлгээ өгөх.
4	Чулуун хороот-50 Дорнод аймгийн Гурванзагал, Чулуун хороот сумдын нутагт Хавтгай: М-50-62-А,Б,В,Г М-50-63-В М-50-65- В,Г М-50-75-А,Б,В,Г М-50-76-А,Б,В,Г М-50-77-А,Б,В,Г М-50-78-А,В М-50-89-А,Б М-50-90-А Код: ЧухХ-50 (2017-2021 он)	5632.0 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлвийн үнэлгээ өгөх.

5	Шүтээн улаан уул-50 Дундговь аймгийн Эрдэнэдалай, Адаацаг, Луус, Дэлгэрхангай сумдын нутаг Хавтгай: L-48-67-В, Г, L-48-79-А, Б, В, Г L-48-91-А, Б, В, Г L-48-92-А, В Код: ШУУ-50 (2017-2020 он)	4324.0 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлвийн үнэлгээ өгөх.
6	Цахир мушгиа уул-50 Ховд аймгийн Алтай, Говь-Алтай аймгийн Тонхил, Бугат сумдын нутагт Хавтгай: L-46-101-А,Б,В,Г L-46-102-А,Б,В,Г L-46-103-А,Б,В,Г Код: ЦМУ-50 (2017-2020 он)	4118.0 кв.км талбайн хэмжээнд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг гүйцэтгэж геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтлыг судалсны үндсэн дээр хэтийн төлвийн үнэлгээ өгөх.
2. Сэдэвчилсэн судалгааны ажил		
7	Монгол орны төв болон зүүн бүсийн алтны хүдэржилт, хэтийн төлвийн судалгаа Монгол орны төв болон зүүн бүсд Код: ТЗМ-Алт-2017(2017-2019 он)	Монгол орны Төв, Зүүн бүсийн алтны орд, илрэл, эрдэсжсэн цэгүүд болон хүдэржилтийн тархалтын зүй тогтлын судалгаа гүйцэтгэж, хэтийн төлөв бүхий талбай ялган үнэлгээ өгөх.
8	Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа Улаанбаатар хотын нутаг дэвсгэр Код: УБ геоэкологи-2017 (2017-2019 он)	Улаанбаатар хотын нутаг дэвсгэр (4707.4 км.кв)-ийн хэмжээнд геологи, геоэкологи, гидрогеологийн өнөөгийн төлөв байдалд суурь үнэлгээ өгөх.
9	Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих голлох ашигт малтмалын хэтийн төлвийн судалгаа. Код: АМС-2017 (2017-2020 он)	Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд голлох ашигт малтмалын тархалт, хуримтлалыг хүдрийн бүс, дүүрэг, зангилаа, талбайн хэмжээнд тогтоож хэтийн төлвийн үнэлгээг хийснээр бүс нутгийн хөгжлийг дэмжих.
10	Налайхын нутаг дэвсгэрт гүйцэтгэх чичирхийлэлийн судалгаа-2017 Код: НЧ-2017 (2017-2018 он)	Налайх дүүргийн нүүрсжилтийн хэтийн төлвийн үнэлгээг гүний геофизикийн судалгаагаар тодорхойлох.
11	Ашигт малтмалын төрөлжсөн судалгаанд сансрын зураг ашиглан тайлал хийх Код: СЗТ-2017 (2017 он)	Монгол орны томоохон ордуудын хэмжээнд АСТЕР төрлийн сансрын зургийн тайлал хийж, ордын загварыг боловсруулах.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14, 15, 16 дугаар зүйлийн шаардлага хангасан байх ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ. Мэдээлэлд дараах зүйлсийг нэмж багтаасан байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар/Нотариатаар баталгаажуулсан байх/;
- Хуулийн этгээдийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр сонгосон талбайн нэр, багцын дугаар;
- Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд санал болгож буй мэргэжлийн боловсон хүчний нэрс, тэдгээрийн чадвар, туршлагыг илтгэсэн мэдээлэл;
- Хуулийн этгээдийн тухайн чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл;
- Хуулийн этгээдийн аудитаар баталгаажуулсан 2015, 2016 оны жилийн эцсийн аудит, нотариатаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ 2017 оны 05 дугаар сарын 9-ний өдрийн 10.00 цагийн дотор доорх хаягаар ирүүлнэ үү.

Жич: Гадаадын этгээд оролцох эрхтэй
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Засгийн газрын 2 дугаар байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 412 тоот өрөө, утас: 51-263010

